



НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/06

Улаанбаатар хот

Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3, 16.5.9 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.3.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоол, 2021 оны 487 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” А/1649 дүгээр захирамж, Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дүрэм батлах тухай А/112 дугаар захирамжийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүрэгт Төрийн хяналт, шалгалтын зарим чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахаар батлагдсантай холбогдуулан тус газрын зохион байгуулалтын бүтэц, ажлын байрны жагсаалт, албан тушаалын ангилал, зэрэглэлийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан бүтцийн хүрээнд өөрчлөлт орсон болон шилжин ирсэн төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, тушаалын хэрэгжилтийг ханган ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (О.Алтангэрэл)-т даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Газрын даргын 2022 оны А/59 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ГАНБОЛД

150500011

Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2023 оны ... дугаар сарын ... -ны өдрийн ... дугаар тушаалын хавсралт

НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, АЛБАН
ТУШААЛЫН ЖАГСААЛТ

| № | Албан тушаалын нэр | Ангилал, зэрэглэл | Орон тоо |
|--|--|-------------------|----------|
| 1. | 2. | 3. | 4. |
| Удирдлага /1/ | | | |
| 1 | Дарга | ТЗ-3 | 1 |
| Захиргаа, санхүүгийн хэлтэс /9/ | | | |
| 2 | Хэлтсийн дарга | ТЗ-4 | 1 |
| 3 | Хүний нөөц, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн | ТЗ-7 | 1 |
| 4 | Хяналт шинжилгээ, үнэлгээ хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн | ТЗ-8 | 1 |
| 5 | Төлөвлөгөө, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн | ТЗ-8 | 1 |
| 6 | Сургалт, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн | ТЗ-8 | 1 |
| 7 | Хуулийн зөвлөх, гэрээ хариуцсан ажилтан | ТҮ-7 | 1 |
| 8 | Үйл ажиллагаа хариуцсан менежер | ТҮ-7 | 1 |
| 9 | Өргөдөл гомдол, шуурхай асуудал хариуцсан ажилтан | ТҮ-6 | 1 |
| 10 | Архив бичиг хэргийн эрхлэгч | ТҮ-5 | 1 |
| Бодлогын хэрэгжилтийн хэлтэс /21/ | | | |
| 11 | Хэлтсийн дарга | ТЗ-4 | 1 |
| 12 | Гэр хорооллоос үүдэлтэй агаарын бохирдол хариуцсан ахлах мэргэжилтэн | ТЗ-7 | 1 |
| 13 | Түлшний бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн | ТЗ-7 | 1 |
| 14 | Хэсэгчилэн дулаан хангамж хариуцсан мэргэжилтэн | ТЗ-8 | 1 |
| 15 | Авто тээврийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн | ТЗ-8 | 1 |
| 16 | Төлөвлөлт гүйцэтгэл, тооцоо судалгаа хариуцсан мэргэжилтэн | ТЗ-8 | 1 |
| 17 | Агаарын бохирдлын нөлөөлөл, тархалтын загварчлал хариуцсан мэргэжилтэн | ТЗ-8 | 1 |
| 18 | Дотоод орчны агаарын бохирдол хариуцсан мэргэжилтэн | ТЗ-8 | 1 |
| 19 | Шингэрүүлсэн хий, сайжруулсан түлшний асуудал хариуцсан мэргэжилтэн | ТЗ-8 | 1 |
| 20 | Барилгын дулаан алдагдал, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн | ТЗ-8 | 1 |
| 21 | Байгальд ээлтэй технологи, сэргээгдэх эрчим хүч хариуцсан мэргэжилтэн | ТЗ-8 | 1 |
| 22 | Хяналт, зохицуулалтын ажилтан | ТҮ-4 | 10 |

| Агаарын чанарын хэмжилт, зохион байгуулалтын хэлтэс /9/ | | | |
|--|--|------|-----------|
| 23 | Хэлтсийн дарга | T3-4 | 1 |
| 24 | Хөдөлгөөнт эх үүсвэрийн хэмжилт хариуцсан ахлах мэргэжилтэн | T3-7 | 1 |
| 25 | Агаар бохирдуулах эх үүсвэрийн хэмжилт хариуцсан мэргэжилтэн | T3-8 | 1 |
| 26 | Агаарын чанарын хяналт хариуцсан мэргэжилтэн | T3-8 | 1 |
| 27 | Орчны хэмжилт хариуцсан мэргэжилтэн | T3-8 | 1 |
| 28 | Дүн шинжилгээ, төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн | T3-8 | 1 |
| 29 | Оператор, техникч | TУ-5 | 3 |
| Хяналт, шалгалтын хэлтэс /8/ | | | |
| 30 | Хэлтсийн дарга, байгаль орчны улсын ахлах байцаагч | T3-4 | 1 |
| 31 | Байгаль орчны улсын ахлах байцаагч | T3-6 | 1 |
| 32 | Байгаль орчны улсын байцаагч | T3-7 | 6 |
| НИЙТ: | | | 48 |

---oOo---